



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/646

Номгон

“Төгс алгоритм” сургуулийн багш нарын  
үйл ажиллагааг дэмжих тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 49 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Элсэлтийн шалгалтад амжилттай бэлтгэж оролцсон сургууль, багш, сурагчдыг шалгаруулах болзолт журмын 5.3.1, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 102 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Элсэлтийн ерөнхий шалгалтад 2021 онд сурагчдыг амжилттай бэлтгэж улс, аймгийн дунджаас дээгүүр амжилт гаргасан Баянхонгор сумын “Төгс Алгоритм” сургуулийн багш нарын үйл ажиллагааг дэмжиж иж бүрэн компьютер олгосугай.

2.Компьютерийн үнэ болох 2,000,000 (хоёр сая) төгрөгийг аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан “Чадварлаг багш” хөтөлбөрийн санхүүжилтээс олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210507